

2018 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 18/005

Улаанбаатар хот

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн шинэчилсэн дүрмийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1, 67-р зүйлийн 67.3.8, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.8 болон Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын 2-р зүйлийн 2.12, Мандал Даатгал ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.7.1, 2018 оны 12 сарын 12-ний өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссоос баталсан санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Мандал Даатгал ХК-ийн шинэчилсэн дүрмийг хавсралтаар баталсугай.
2. Мандал Даатгал ХК-ийн шинэчилсэн дүрмийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн этгээдийг бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал (Б.Жавхлан)-д даалгасугай
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг нэн даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлан)-д даалгасугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА**



Ө.ГАНЗОРИГ

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7, 62.1.13, 67-р зүйлийн 67.3.8, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.8 болон Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын 2-р зүйлийн 2.12, Мандал Даатгал ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.8.1, 2018 оны 12 сарын 12-ний өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссоос баталсан санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мандал Даатгал ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдээс олонхын санал авсан дараах нэр дэвшигчдийг тус тус төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай:

- а. Ноён Ө.Ганзориг
- б. Ноён Н.Монсор
- в. Ноён О.Ганжолоо
- г. Ноён А.Амундра
- д. Ноён Ч.Ванчин-Эрдэнэ
- е. Ноён Б.Жавхлан

2. Мандал Даатгал ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдээс олонхын санал авсан дараах нэр дэвшигчдийг тус тус төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай:

- а. Ноён Жэймс Бернард Двайер
- б. Ноён Ж.Дэлгэрсайхан
- в. Ноён Н.Мандуул

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг нэн даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлан)-д даалгасугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА**



Ө.ГАНЗОРИГ